



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/313

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 108 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8.8.11 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Цалин хөлс тогтоох аргачлал”-ын 6.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлдвэрлэлийн газрын харьяа “Нислэг үйлдвэрлэлийн зохицуулалт, инженерингийн хэлтсийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “НҮЗИХ-ийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгож, ур чадварын нэмэгдэл тогтооход мөрдөх аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Шинэчлэн баталсан журам, аргачлалын дагуу ажилтнуудын мэргэшлийн зэрэгт өөрчлөлт оруулах, тавигдах шаардлага хангасан ажилтнуудад шинээр мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулж саналаа танилцуулахыг Захиргаа, удирдлагын газрын захирал /Э.Мөнхмарал/, Үйлдвэрлэлийн газрын захирал бөгөөд Ерөнхий нисгэгч /Б.Гантулга/ нарт тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/181 тоот тушаал, 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн Б/354 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.МӨНХТАМИР





## НИСЛЭГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ИНЖЕНЕРИНГИЙН ХЭЛТСИЙН АЖИЛТНУУДАД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “МИАТ” ТӨХК /цаашид “компани” гэнэ/-ийн Нислэг үйлдвэрлэлийн зохицуулалт инженерингийн хэлтсийн ажилтан /цаашид “ажилтан” гэнэ/-д олгох мэргэшлийн зэргийн ангилал, тавигдах нөхцөл, шаардлага, хугацаа болон ур чадварын түвшинг тогтоох, нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам дараах ерөнхий шаардлагыг хангасан ажилтанд хамаарна:
  - 1.2.1. Нислэг үйлдвэрлэлийн зохицуулалт, инженерингийн хэлтсийн үндсэн орон тоонд ажиллаж байгаа ажилтан /ажил, үүрэг хавсралт гүйцэтгэж байгаа өөр нэгж, хэлтсийн ажилтанд хамаарахгүй/;
  - 1.2.2. Нислэг зохицуулалт, хяналтын зааврын 10 дугаар бүлэгт заасан сургалтад хамрагдан гэрчилгээжсэн, дадлага, туршлага бүхий;
  - 1.2.3. нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой эрх, үүргийг бие даан хэрэгжүүлэх, хариуцлага хүлээх чадвартай;
  - 1.2.4. компанийн ашиглаж буй нийт агаарын хөлгийн төрлөөр гэрчилгээжсэн эрх бүхий хөдөлгөөн хяналт, ачаалалт хяналт, агаарын хөлгийн диспатчер, агаарын хөлгийн үзүүлэлтийн тооцоолол гүйцэтгэх чадвартай;
  - 1.2.5. компанийн нислэг үйлдэж буй бүх чиглэлд холбогдох зөвшөөрөл, агаарын навигацийн хууль дүрмийг хэрэгжүүлэх чадвартай.
- 1.3. Мэргэшлийн зэргийг үнэлж дүгнэхдээ үндэс угсаа, нас, хүйс, нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн байгууллагын харьяалал зэргээс үл хамааран адил тэгш хандаж, шударга, ил тод байх зарчмыг баримтална.
- 1.4. Ажилтанд олгох албан тушаалын үндсэн цалин, бусад нэмэгдэл болон нэмэгдэл хөлс /илүү цаг, удаан жил, хоолны мөнгө, шагнал урамшуулал, баяр ёслолын нэмэгдэл, шөнийн нэмэгдэл, хүйтний, хортой нөхцөлийн нэмэгдэл гэх мэт/-ийг компанийн хэмжээнд дагаж мөрдөгдж буй нийтлэг бусад журмаар зохицуулна.
- 1.5. Мэргэшлийн зэргийн шаардлага хангасан ажилтанд ур чадварын зохих нэмэгдлийг олгох ба тусдаа мэргэшлийн зэргийн нэмэгдэл давхардуулан олгохгүй.
- 1.6. Мэргэшлийн зэрэгт тавигдах шаардлага хангасан ажилтанд 1 зэрэг олгох ба давхар мэргэшлийн зэрэг олгохгүй.
- 1.7. Мэргэшлийн зэргийг шат дараалан олгох зарчим баримтална.
- 1.8. НҮЗИХ-ийн ажилтнуудад олгох ур чадварын нэмэгдлийг тухайн жилийн цалингийн фонд сантай уялдуулан мэргэжлийн зэрэг авах, ахиулах ажилтны тоонд хязгаарлалт тавих эсэх асуудлыг комиссын хурлаар хэлэлцэн Гүйцэтгэх захиралд танилцуулан шийдвэрлүүлнэ.

### Хоёр. Мэргэшлийн зэрэгт тавигдах шалгуур үзүүлэлт, мэргэшлийн зэрэг олгох

- 2.1. Ажилтанд мэргэшлийн зэрэг олгох гэдэг нь тухайн ажлын байранд ажилласан хугацаа, мэргэшсэн байдал, хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны

- тодорхойлолтоор хүлээсэн үүрэгт ажлын гүйцэтгэл, өөрийн ур чадварыг хөгжүүлэх, бусад ажлын байруудад хөрвөн ажиллахад шаардагдах ур чадваруудыг жил бүр шалган тогтоох үйл явц юм.
- 2.2. Энэхүү журмын дагуу мэргэшлийн зэргийг үнэлж дүгнэхдээ дараах аргачлалыг ашиглана.
- 2.2.1. ажлын стандартын арга;
- 2.2.2. ярилцлагын арга;
- 2.2.3. үйл ажиллагааны явцад ажлын байран дээрх ажиглалтын арга.
- 2.3. Ажилтанд мэргэшлийн зэрэг олгоходо тухайн ажлын байранд тогтвортой ажилласан байдал, тухайн ажилтны мэргэжлийн ур чадварыг чухалчлахаас гадна ажилтны өөрийгөө хөгжүүлсэн байдал, идэвхи санаачлага болон ажил үүргийн онцлогийг харгалзан үзэж ур чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нягтална.
- 2.4. Шинээр ажиллаж эхэлсэн ажилтан нь тухайн нэгжид ажиллаж эхэлснээс буюу Гүйцэтгэх захирлын тушаал гарч хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 12 сар, эсхүл тухайн ажлын байранд эрх авч гэрчилгээжсэнээс хойш 12 сарын дараа мэргэшлийн зэргийн шалгалтад хамрагдах эрх нээгдэнэ.
- 2.5. Ур чадварын шалгуур үзүүлэлтэд хамаарах мэргэшлийн зэргийг А, В, С ангилалд хуваах ба харгалзах мэргэшлийн зэрэглэлийг албан тушаал харгалзахгүйгээр Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдүүлнэ.
- 2.6. Мэргэшлийн зэрэг олгох, ур чадварын нэмэгдэл олгох эсэхийг энэ журамд заасан Комисс хараат бусаар ажиллаж саналаа нэгтгэн Гүйцэтгэх захиралд танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 2.7. Комисс нь үндсэн болон нэмэлт гишүүдээс бүрдэх ба үндсэн 7 гишүүнтэй байна. Комиссын үндсэн гишүүнд дараах албан тушаалтан орно:
- 2.7.1. Үйлдвэрлэлийн газрын захирал бөгөөд Ерөнхий нисгэгч;
- 2.7.2. Захиргаа, удирдлагын газрын захирал;
- 2.7.3. Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга;
- 2.7.4. Нислэг үйлдвэрлэлийн зохицуулалт, инженерингийн хэлтсийн дарга
- 2.7.5. Нислэгийн хэлтсийн дарга
- 2.7.6. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч
- 2.7.7. Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн Хүний нөөцийн мэргэжилтэн /комиссын нарийн бичгийн үүрэг гүйцэтгэнэ/
- 2.8. НҮЗИХ-ийн хамт олны хурлын шийдвэрээр сонгогдсон тухайн хэлтсийн ажилтнуудын мэргэшлийн зэрэг тогтоож чадахуйц ур чадвар, дадлага туршлага бүхий 2 ажилтныг нэмэлт гишүүнээр сонгох бөгөөд нэмэлт гишүүн нь Комиссын хуралд санал өгөх эрхгүйгээр хөндлөнгийн ажиглагчаар оролцно.
- 2.9. Комисс нь дараах зарчмыг баримтална:
- 2.9.1. Өрөөсгөл хандаж тогтмол нэг маягийн үнэлгээ өгөхгүй байх;
- 2.9.2. Нэг шинж дээр тулгуурлахгүй, анхны сэтгэгдэлээр хандахгүй байх;
- 2.9.3. Хэт зөвлөн буюу хэт хатуу, хувийн үзэмжээр хандахгүй байх;
- 2.9.4. Дундыг баримтлахгүй зөвхөн бодит үзүүлэлтүүдэд тулгуурлах.
- 2.10. Ажилтны мэргэшлийн зэргийг тогтоохтой холбогдуулан Комисс нь дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:
- 2.10.1. компанид 3 жил буюу түүнээс дээш хугацаагаар нэг төрлийн зэрэгтэй байгаа ажилтанд мэдлэг чадвараа дээшлүүлэх, бие даан суралцах зөвлөмж зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд зэргийг бууруулах санал гаргах;

- 2.10.2. Мэргэшлийн зэрэг тогтоох шалгалтын үеэр өгөгдсөн үүрэг даалгавар зөвлөмжийг дараагийн шалгалтын үеэр баталгаажуулж, хэрэгжилтийн үр дүнг шалгалтын дүгнэлтэд оруулах;
- 2.10.3. Ажилтны мэргэшлийн зэргийн үзүүлэлтийг шалгах аргачлал боловсруулан, зэрэглэл тогтоох ажлыг удирдан зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангах;
- 2.10.4. НҮЗИХ-ийн нийт ажилтнуудад урьдчилан мэдээлж, тэдэнд зохих бэлтгэл хангах хугацаа олгохуйцаар зохион байгуулах, мэргэшлийн зэргийн журмыг танилцуулах;
- 2.10.5. Мэргэшлийн зэрэг тогтоохтой холбогдсон бичиг баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх болон хадгалж хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэх;
- 2.10.6. Ажилтнуудын хувийн хэрэгт мэргэшлийн зэргийн мэдээллийг цаг тухай бүрт нь оруулан, ур чадварын өсөлт, бууралт, хэрэгцээ шаардлагаыг судалж, шийдвэрлэх арга хэлбэрийг тодорхойлох.
- 2.11. Комисс мэргэшлийн зэрэг тогтоох шалгалтын хугацааг товлоно. Ингэхдээ бэлтгэл ажлыг хангахад шаардагдах хугацаа, ачааллыг тооцоолсон байна.
- 2.12. НҮЗИХ-ийн дарга болон сонгогдсон 2 гишүүн нь мэргэшлийн зэрэг ахих шаардлага хангасан ажилтнуудын жагсаалтыг гарган Комисст танилцуулна.

**Гурав. Мэргэшлийн зэргийн ангилал, мөрдөх хугацаа**

- 3.1. Комиссын зарласан товын дагуу энэ журамд заасан аргачлалаар ур чадварыг үнэлж Хүснэгт 1-д заасан ангиллаар мэргэшлийн зэргийг олгоно.

Хүснэгт 1

A зэрэг	B зэрэг	C зэрэг
A1	B1	C1
A2	B2	C2
A3	B3	C3
Sr		

- 3.2. Ажилтанд мэргэшлийн зэрэг олгосон тухай мэдээллийг нэгтгэн компанийн Санхүү, нягтлан бodoх бүртгэлийн хэлтэст хүргүүлэх ба мэргэшлийн зэрэг тогтоосон сараас эхлэн ажилтны сар бүрийн сүүлийн цалин дээр ур чадварын нэмэгдлийг олгоно.
- 3.3. Мэргэшлийн зэрэг олгосноос хойш 12 сараас багагүй, 14 сараас ихгүй хугацааны дотор багтаан дараагийн шалгалтыг зохион байгуулна. Тухайн зэргийн хүчинтэй хугацаа нь 36 сараас ихгүй байна.
- 3.4. Ажилтан мэргэшлийн зэргээ ахиулах хүсэлтээ дараагийн хуваарыт шалгалтын жагсаалтад бүртгүүлнэ. Тухайн жилд мэргэшлийн зэргээ ахиулах хүсэлт бичгээр ирээгүй тохиолдолд Комисс нь тухайн жилийн шалгалтыг өнжиж болно.
- 3.5. Ажилтан нь ажил үүргээ гүйцэтгээгүй 3 сараас дээш хугацаанд завсардсан тохиолдолд мэргэшлийн зэргийг хүчингүй болсонд тооцох ба ур чадварын нэмэгдлийг дараагийн шалгалтын хуваарыт хугацаа хүртэл цуцлагдсанд тооцно.
- 3.6. 24 сараас дээш хугацаагаар завсардсан тохиолдолд шинэ ажилтны жишгээр журам хэрэгжих болно. Завсардсан ажилтны мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тогтооходоо өмнө эзэмшиж байсан зэрэглэлийг үндэслэл болгохгүй.

- 3.7. Давагдашгүй хүчин зүйл болон хүндэтгэх шалтгааны улмаас мэргэшлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд өмнө тогтоосон зэргийг дараагийн хуваарыт шалгалт хүртэл сунгагдсанд тооцно.
- 3.8. Комиссын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй ажилтан гомдлоо бичгээр компанийн Гүйцэтгэх захиралд гаргаж болно.

---oOo---

НИСЛЭГ УЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ИНЖЕНЕРИНГИЙН ХЭЛТЭС

НУЗИХ-ИЙН АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОЖ, УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ТӨГТООХОД МӨРДӨХ АРГАЧЛАЛ

No	Мэргашийн Зэрэг	Ур чадварын шаардлагууд	Тайлбар	Үр чадварын нэмждэл тапсан тушаалын үндсэн цэлийн хувь/
1	C1	<ul style="list-style-type: none"><li>a) "МИАТ" ТӨХК-ийн Агаарын хөлгийн диспачетчерийн эрх бүхий гэрчилгээжсэн байх;</li><li>b) Эрхэлсэн ажлын байрандаа тасралтгүй 12 сараас доошгүй хугацаагаар В3 зэрэгтэй ажилласан байх;</li><li>c) Агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлтийн чиглэлээр аль нэг функцийг гүйцэтгэх чадвартай байх;</li><li>d) Үйл ажиллагааны төлөвлөлт, нислэгийн зөвшөөрөл хариуцсан ажлын байранд ажиллах ур чадвартай байх;</li><li>e) Нислэг үйлдвэрлэлийн нарийн мэргэшшийн сургалт (Performance, Navigation, CNS, W&amp;B)-дын аль нэгт хамралсан байх;</li><li>f) "МИАТ" ТӨХК-ийн шинэ чиглэл, захналгат нислэгийн тооцоололт, судалгаа хийх чадвартай байх;</li><li>g) TOEIC-ийн 650-аас дээш оногийн байх.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>OCC-2 зэргийн 3-р дэвийн 85%;</li></ul>	Шалгах комиссын дүгэлтээр b) – g) нөхцөлүүдийн дүрын 5 болон а), шаардлага, нийт 6 шаардлагыг хангасан тохиолдолд уг эзэртэлэйг олонго.
2	C2	<ul style="list-style-type: none"><li>a) Эрхэлсэн ажлын байрандаа тасралтгүй 36 сараас доошгүй хугацаагаар C1 зэрэгтэй ажилласан байх;</li><li>b) Нислэгийн үзүүлэлтийн инженерингийн чиглэлийн аль нэг ажлын хэсгүүдэд орж 80%-иас дээш үнэлгээтийн ажилласан байх; Үнэлгээг комисс тогтооно/</li><li>c) Хэлтэс дотор хэрэгжих бүй 4-өөс доошгүй дэд ажлын хэсгүүдэд орж 80%-иас дээш үнэлгээтийн ажилласан байх;</li><li>d) TOEIC-ийн 700-аас дээш оногийн байх;</li><li>e) A,B,C зэрэг хамаарах ажлын байранд багтлах эрх бүхий байх;</li><li>f) Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй үзүүлэлт оруулах чадвартай байх;</li><li>g) FAA буюу АНУ-ын ИН-ийн байгууллагын агаарын хөлтүйн диспачичийн үнэмлэх эзэмшилсэн байх;</li><li>h) C зэрэг хамаарах эрхэлсэн ажлын байрандаа 60 сараас доошгүй хугацаагаар ажил үүрэг гүйцэтгэсэн байх;</li><li>i) Нислэгийн үзүүлэлтийн нарийчилсан тооцоолыг бие даан болон ажлын хэсэгт орж гүйцэтгэх чадвартай байх ( Жны. Oxygen, Drift Down Study, ETOPS, Polar Ops г.м.);</li><li>c) A,B,C зэрэг хамаарах ажлын байранд багтлах эрх бүхий байх;</li><li>d) Инженерингийн чиглэлийн 2-ос доошгүй ажлын байранд хөрвөн ажиллах чадвартай байх;</li><li>e) Агаарын хөлгийн үзүүлэлтийн нарийн тооцоолтын процедуру, журам боловсруулах чадвартай байх (Х/Нь: EOSID, Derate, Fuel Policy г.м.);</li><li>f) Нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системийн администратор хийх чадвартай байх;</li><li>g) Нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оновчтой шинэ санал, санаачилга гарган үйл ажиллагаанд нэвтрүүлсэн, компанийн хэмжээнд зохион байгулдасан ажлын хэстийн бүрэлдэхүнд орж, үр дүнтэй ажилласан байх;</li><li>h) TOEIC-ийн 700-аас дээш оногийн байх;</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>OCC-2 зэргийн 3-р дэвийн 110%;</li></ul>	Шалгах комиссын дүгэлтээр б) – g) нөхцөлүүдийн дүрын 5 болон а), шаардлага, нийт 6 шаардлагыг хангасан тохиолдолд уг эзэртэлэйг олонго.
3	C3	<ul style="list-style-type: none"><li>g) Нислэг үйлдвэрлэлийн 36 сар болон түүнээс дээш хугацаагаар хадгалсан ажилтныг, шалгалтын комисс авч хэлэлцэн, ур чадвар болон дадлага түршлэгтын хувьд хангантай гэсэн үнэлгээ өгсөн тохиолдолд тус зэргийг тогтооно**</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>OCC-1 зэргийн 3-р дэвийн 110%;</li></ul>	**SI зэрэгтэй ажилтан тус хэлтсийн нийт ажилтнуудын 10%-мас хэтрэхгүй байна.
4	Senior (Sr)			

№	Мэргэшний Зэрэг	Үр чадварын шаардлагууд	Тайлбар	Үр чадварын нэмэгдэл /албан тушаалын үндсэн цалингийн хувь
1	B1	<p>a) Гар аргаар болон автомат систем ашиглан "МИАТ" ТӨХК-ийн агаарын хөлгүүдийн жин төвлөрөлт, ачаалалтын тооцоо хийх эрх бүхий байх;</p> <p>b) Сүүлийн 12 сарын хугацаанд ачаалалт, хяналтын давтан сургалтад хамрагдан, гарчилгээжсэн байх;</p> <p>c) Эрхэлсэн ажлын байрандаа тасралтуй 12 сараас доошгүй хугацаагаар А3 зэрэгтай ажилласан байх;</p> <p>d) Хэлээс дотор хэрэгжиж буй 3-асас доошгүй дэд ажлын хэсгүүдэд орж 80%-иас дээш үнэлгээтийг ажилласан байх; Үнэлгээг комисс тогтооноо/</p> <p>e) TOEIC 600-с доошгүй оноготой байх;</p> <p>f) УБ хот руу нислэг үйлдэж буй нийт гэрээт гадаадын агаарын тээвэрлэгчийн ачаалалт, хяналтын тооцоог хийх эрхтэй байх;</p> <p>g) AIMС системийн өгөгдөөс нислэгийн мэдээнд дун шинжилгээ хийж, (Taxi-in &amp; out, average baggage, cargo g.m.) боловсруулах чадвартай байх.</p>	<p>Шалтгах комиссын дүгнэлтээр b) – g) нэхцэлүүдийн дүрүн 5 болон a) шаардлага, нийт 6 шаардлагыг хангасан тохиолдолд уг зэрэглэлийг олондоо.</p>	OCC-3 зэртийн 3-р дэвийн 45%
2	B2	<p>a) Эрхэлсэн ажлын байрандаа тасралтуй 12 сараас доошгүй хугацаагаар B1 зэрэгтай ажилласан байх;</p> <p>b) МИАТ ТӨХК болон гэрээт гадаадын агаарын тээвэрлэгчдийн ачаалалт, хяналтын тооцоо хийжд батшилах, дадлажуулах чадвартай байх;</p> <p>c) Нислэг үйлдвэрлэлт инженеринийн чиглэлээр аль нэг функцийг гүйцэтгэх чадвартай байх;</p> <p>d) Ачаалалт хяналтын диспетчерийн хамаарал бүхий баримт бичиг, заавар журамд өөрчлөлт оруулах чадвартай байх;</p> <p>e) Англи болон монгол хэлээр албан бичиг боловсруулах чадвартай байх;</p> <p>f) TOEIC-ийн 620-с дээш оноготой байх;</p> <p>g) Агаарын хөлтүйн диспетчерийн анхан шатны сургалтын өмнөх бэлтгэл сургалтад хамрагдсан байх;</p> <p>h) Агаарын хөлтүйн диспетчерийн Урээгт ажлын аль нэг функцийг гүйцэтгэх чадвартай байх.</p>	<p>a) TOEIC 650-с доошгүй оноготой байх;</p> <p>b) Эрхэлсэн ажлын байрандаа тасралтуй 12 сараас доошгүй хугацаагаар B2 зэрэгтай ажилласан байх;</p> <p>c) Өөрийн хариусан чиг үүрэгтэй холбоотой стандарт, заавар журамд санал оруулж өөрчлөлтийг хийх чадвартай байх;</p> <p>d) Нислэгийн үзүүлэлтийн тооцонд ашиглагддаг ачаалалтын хязгаарлалтын тооцололтыг хийх анхан шатны мэдээтэй байх;</p> <p>e) Инженеринийн чиглэлийн аль нэг ажлын байранд орлон ажиллах чадвартай байх;</p> <p>f) Ачаалалт хяналтын диспетчерийн ажлын байранд багшил, шалтгах эрх бүхий байх;</p> <p>g) Компанийн хэмжээнд эхийн байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сүүлийн 12 сард оролцож, үр дүнтэй ажилласан байх.</p>	OCC-3 зэртийн 3-р дэвийн 60%
3	B3			

No	Мэргэшшийн Зэрэг	Ур чадварын шаардлагууд	Тайлбар	Ур чадварын кэмээдэд ланбан ушаалын үндэснээ цалинижүүлэх
1	A1	<ul style="list-style-type: none"> <li>а) Сүүлийн 12 сарын хугацаанд холбогдох ажлын байранд тасралттай ажилласан, дотоод давтан сургалтад амжилттай хамрагдсан байх;</li> <li>б) Хөдөлгөөн хянцалтын диспетчерийн ажлын бие даан ажиллах дадлага эзэмшийн байх;</li> <li>в) Дотоод завар жүрүүлийн цаасан болон цахим хувилбарын өөрчлөлтийг програм хангамжид оруулж байршуулах чадвартай байх;</li> <li>г) TOEIC 500-с доошгүй онootой байх;</li> <li>д) AIMS системийн орчинд ажиллах, тоо баримт мэдээлэл цүгпуулах, анхан шатны судалгаа гаргах чадвартай байх;</li> <li>е) Нислэгийн баримт бичиг (Tip Files)-ийн бурдлуулэлт хийх чадвартай байх;</li> <li>ж) Цаг агаарын зурган болон текстстан мэдээг уншиж сийлгох, дамжуулах чадвартай байх.</li> </ul>		OCC-4 зэргийн 3-р дэвийн 10%
2	A2	<ul style="list-style-type: none"> <li>а) Эрхэлсэн ажлын байрандаа тасралттай 12 сараас доошгүй хугацаагаар A1 зэрэгтай ажилласан байх;</li> <li>б) Инженеринийн болон хэлтсийн 8 цагийн ажлын аль нэг функцийг гүйцэтгэх дадлага туршлага, чадвартай байх;</li> <li>в) Жин төвлөрөлтийн талаар анхан шатны онолын мэдлэгтэй байх;</li> <li>г) TOEIC 520-с дээш онootой байх;</li> <li>д) Радио холбоогоор мэдээлэл солилцох, стандарт фразеологийн чадварыг эзэмшийн байх;</li> <li>е) Нислэгийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтийн хянцалтанд 3 сараас доошгүй хугацаанд ажилласан дадлага туршлага бүхий,</li> <li>ж) Хэлтэс дотор хэрэгжих буй 1-ээс доошгүй дэд ажлын хэсэгт орж 80%-иас дээш үнэлгээтийг ажилласан байх. /Үнэлгээг комисс тогтооно/</li> <li>з) Эрхэлсэн ажлын байрандаа тасралттай 12 сараас доошгүй хугацаагаар A2 зэрэгтэй ажилласан байх;</li> <li>и) Хэлтэс дотор хэрэгжих буй 2-ос доошгүй дэд ажлын хэсэгт орж 80%-иас дээш үнэлгээтийг ажилласан байх. /Үнэлгээг комисс тогтооно/</li> <li>к) Өөрийн ажлын байрны чиг үүрэгтэй холбоотой завар журамд өөрчлөлт оруулах чадвартай, эсвэл оруулсан туршлагатай байх;</li> <li>л) Англи монгол хэл дээр албан бичиг боловсруулах, чадвартай байх;</li> <li>м) Гар агаар болон DCS систем ашиглан жин төвлөрөлт, ачаалалтын тооцоо хийх эрх бүхий байх;</li> <li>н) Хөдөлгөөн хянцалтын диспетчерийн ажлын байранд багшах, дадлагажуулах, шалгах эрх бүхий байх;</li> <li>о) Инженеринийн болон хэлтсийн 8 цагийн ажлын аливаа 2 төрлийн функцийг гүйцэтгэх дадлага туршлага, чадвартай байх.</li> </ul>		OCC-4 зэргийн 3-р дэвийн 20%
3	A3	<ul style="list-style-type: none"> <li>п) TOEIC 550-с дээш онootой байх;</li> </ul>		OCC-4 зэргийн 3-р дэвийн 25%

---oo---